

**“МОНГОЛЫН ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВЭР” /МИАТ/ ТӨХК-ИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.18

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Монголын иргэний агаарын тээвэр” /МИАТ/ ТӨХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Танилцуулга

МИАТ ТӨХК-ийн 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **85,8%**-тай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МИАТ ТӨХК-ийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
23	11	2	4	3	-	-	3	85.5%

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
10	10	-	-	-	100%

2.3. Сайдын тушаалын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
5	1	1	-	3	50%

2.4. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Төсөв/гүйцэтгэл	9	6	-	-	-	3	100%
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	5	5	-	-	-	-	100%
бусад	8	8	-	-	-	-	100%
Нийт	22	19	-	-	-	3	100%

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	50%	30%	хамаа ралгүй	
Нийт	46	30	1	1	2	12	93,5%

Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

МИАТ ТӨХК нь ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг ЗТХЯ-ны Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хүрэх түвшинг улирал бүрээр төлөвлөн Зам, тээврийн яамны холбогдох газруудаар хянуулж, батлан ажилласан байна.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” шинэчлэн батлагдсантай холбоотой байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

2. Хэрэгжилтийн байдал:

1) МИАТ ТӨХК-ийн 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **85,8%**-тай байна.

2) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 23 арга хэмжээнээс 65% нь хүрэх түвшиндээ хүрсэн буюу хүрч байгаа, 35% нь төлөвлөсөн түвшиндээ хүрээгүй байна.

3) 2025 оны хагас жилд 522,200 зорчигч, 6000 тн ачаа тээвэрлэхээр төлөвлөснөөс олон улсын хуваарьт 13 чиглэлд, захиалгат 9, Орон нутгийн 7 чиглэлд, захиалгат 1 чиглэлд, 1958 удаагийн нислэг үйлдэж, 543,225 зорчигч, хуваарьт болон захиалгат нислэгээр 4245 тонн ачаа тээвэрлэсэн үзүүлэлттэй байна.

4) МИАТ ТӨХК нь 2025 оны хагас жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 424.6 тэрбум төгрөгийн орлого олж, 462.7 тэрбум төгрөгийн зардал гарган, 38 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

5) “Чингис хаан” ОУНБ-д Карго ачаа, шуудан дамжин өнгөрүүлэх терминалын барилга, газрын тусгай үйлчилгээний техник, тоног төхөөрөмж, автомашин байрлуулах гражийн барилга барих ажлуудыг өгсөн зөвлөмжийн дагуу 2025 оны төлөвлөгөөнд тусгасан боловч “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг өргөтгөх төсөл эхэлж байгаатай холбоотой эдгээр ажил нь хэрэгжих боломжгүй болсон байна.

Санал, зөвлөмж

1. АНУ, БНХАУ-ын Эрээн, Сингапур-Сидней чиглэлд шууд хуваарьт нислэг үйлдэх ажлыг эрчимжүүлэх;
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудит шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн сахилга батыг сайжруулах, алдаа, дутагдал гаргахгүй байхад анхаарч хяналтыг сайжруулах;
3. 2025 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх;
4. Бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн болон хяналт-шинжилгээний журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэхдээ дараах зүйлсийн анхаарах. Үүнд:
 - Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд МИАТ ТӨХК болон яам, ИНЕГ, ИНҮТ ТӨХХК-ын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг уялдуулах;
 - Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх;
 - “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг өргөтгөх төсөл хэрэгжүүлэх болсонтой холбоотой хэрэгжих боломжгүй болсон ажлуудыг хасуулах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР